

## ДЭЛ УУЛЫН ЖИРИМИЙН ХУДГИЙН БИЧЭЭС

Ц.Баттулга, Д.Сүхбаатар

Монгол Улсын Их Сургууль

**Өгүүллийн товч утга:** Дундговь аймгийн Өлзий сумын нутаг дахь Дэл уулнаас олдсон тав дахь руны бичээсийн талаар танилцуулсан болно.

**Түлхүүр үг:** Дэл уул, хадны зураг, эртний бичээс, тамга, руны бичиг

Дундговь аймгийн Өлзийт сумын Тагт багийн нутаг дахь Дэл уул нь хадны зураг, эртний үсэг бичиг, тамга тэмдгийн зүйлээр нэн арвин билээ. Дэл уулаас дөрвөн хэсэг руны бичиг, 665 оны үед холбогдох нангиад бичээс<sup>1</sup>, үл үншигдах (согд, уйгур, монголын аль болох нь тодорхойгүй) бичээс, төвд бичээс олдоод байгаа билээ. Тэдгээр бичээсээс харьцангуй сайн судлагдсан нь Дэл уулын руны бичиг болно<sup>2</sup>.

Дэл уулнаас руны бичгийн шинэ дурсгал олдсон нь энэ уулнаас олдсон тав дахь руны бичиг болох юм. Эл бичээсийг “Дэл уулын соёлын өв” хэмээх кино бүтээхээр явахдаа үзэж гэрэл зураг болон кино хальсанд буулган авчээ. Энэ бичээс нь Дэл уулын баруун Билүүнээс 15 орчим км, Дэл уулын нэг, гурав, дөрөвдүгээр бичээсийг бичсэний адил маш хурц үзүүртэй зүйлээр бичсэн бөгөөд хоёрдугаар мөрийн үсгүүд төдий л тодорхой бус тул тоймлон уншиж нийтэд мэдээллэх зорилго тавьсан болно. Иймд цаашид дахин нарийвчлан судлууштайг тэмдэглэе.

Бичээсийн эхийн сийрүүлгэ;

Дэл уул  
Дэл уул

Үсгийн галиг;

<sup>1</sup> Ц.Баттулга, Ц.Төрбат, Б.Ганчимэг, Дэл уулнаас шинээр олдсон хятад бичээс, -Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг, МУИС, Монгол судлалын сургууль, Боть XVII (227), Улаанбаатар, 2001, 103-105 дугаар тал. Д.Хүүхэн баатар, Дэл Хөнжлийн түүх, соёлын дурсгал, -МУИС, НШУС, Эрдэм шинжилгээний бичиг, Түүх- IV, №245(24), УБ., 2005, 13-16 дугаар тал.

<sup>2</sup> Ю.Болдбаатар, Дэл уулын нэгдүгээр бичээс, -Mongolica Vol.(31)\* Улаанбаатар, 2000, 219-226 дугаар тал; Ц.Баттулга, Дэл уулын нэгдүгээр бичээсийг дахин нягтлах нь, -МУИС Монгол хэл соёлын сургууль, Эрдэм шинжилгээний бичиг, XXII боть, III дэвтэр, Улаанбаатар, 2004, 12-17 дугаар тал; Ц.Баттулга, Дэл уулын баруун Билүүний II, III бичээс, Археологийн судлал, Tom. XXXVIII, fasc. Улаанбаатар, 1998, 109-115 дугаар тал; Ц.Баттулга, Монголын руны бичгийн бага дурсгалууд, Тэргүүн дэвтэр, -Corpus Scriptorum, Tom.I, Centre for Turkis Studies, Shool of Mongolian Language and Culture, National University of Mongolia, Улаанбаатар, 2005, 141-156 дугаар тал.

1. [Nt] W Y W R oQ m Q a Q W N m a
2. [BY] ki i I a R m Y a

Үсгийн галиг;

1. [anta] uja uruqumqa qonum
2. [bay] kil aram aya

Орчуулга;

1. (энд) язгуур урагт минь ойр дотно
2. (баян) байлга. Эхэн сар (аа)

Эл бичээсийг “Удам язгуурт минь ойр байлга! Хаврын эхэн сараа” хэмээн утгачилан буулгаж болох юм.

Тайлбар:

1. [Ø] [anta] –Бичээсийн эхэнд байгаа хагас саран хэлбэртэй тэмдэгтийг бид [Ø] anta үсэг тэмдэгт байж болзошгүй хэмээн үзлээ.

﴿ uya- Монгол хэлний язгуур гэх үгтэй ижил утгатай. Уг үг нь Монголын нууц товчоонд “cingga-qahan-nu huja’ur...”<sup>3</sup>, дөрвөлжин бичгийн дурсгалуудад, тухайлбал Тогоонтөмөр хааны 1362 оны зарлиг, 1345 онд холбогдох Цавчаал боомтын зүүн хананы бичээснээ hu-ja\_-’ur гэсэн хэлбэрээр тохиолдоно<sup>4</sup>.

﴿ aram ay(a)- Арам сар. Энэ нь “арам” хэмээх сарын тухайд эртний түрэг хэлний толь бичигт “Название первого месяца в году в уйгурском календаре” г’т гэх үсгээс үүсэлтэй болохыг тэмдэглэжээ<sup>5</sup>. Бичээст үнэхээр “арам сар” гэж буй бол Монголын руни бичгийн дурсгалд анх удаа сарын нэр дурдагдаж байгаа хэрэг болно. Харин уйгур бичгийн дурсгалд “qoyn yil aram ay (хонь жил тэргүүн сар), taq’yu aram ay (тахиа [жил] тэргүүн сар), küs’kü aram ay (хулгана [жил] тэргүүн сар), tavišyan yil aram ay (туулай жил тэргүүн сар)” гэх зэргээр арам хэмээх сарын нэр цөөнгүй тохиолддог ажээ<sup>6</sup>. Он цагийн хувьд бичээс нь энэ газар согд лам нар ирж маанийн шашны сүм хийд байгуулан, ном судар орчуулж эхэлсэн буюу өөрөөр хэлбэл Уйгур

<sup>3</sup> I.de.Rachewiltz, Index to the Secret History of the Mongols, Bloomington, 1972, pp.13.

<sup>4</sup> Ё.Жанчив, Дөрвөлжин үсгийн монгол дурсгал, Monumenta Mongolica: Tomus III, Centre for Mongol Studies, National University of Mongolia, Улаанбаатар, 2002, 103-105; 112-117 дугаар тал.

<sup>5</sup> Древнетюркский словарь, Ленинград, 1969, стр.50.

<sup>6</sup> ウイグル文契約文書集成. 著者 山田 信夫. 編者小田 壽典 P. ツィーメ梅村 坦 森安 孝夫 大阪大学出版会 (Nobuo Yamada, Sammlung Uigurischer Kontrakte, Herausgegeben von Juten Oda, Peter Zieme, Hiroshi Umemura, Takao Moriyasu, Osaka University Press,) 1993, p.7, 23, 71, 160.

улсын эхэн үед холбогдож болох юм. Бичээсийн дүрс бичлэг, гэрэл зурагт харьцангуй тодорхой буусан эхэд тулгуурлаж уншсан бөгөөд бид (Ц.Баттулга) нүдээр үзэж шалгаагүйг энд зориуд тэмдэглэх хэрэгтэй.

Монгол цаг тооллоор энэ сар нь хаврын эхэн сар буюу хуви (qubi ) сарыг хэлж буй бололтой. Нэгдүгээр сарыг нангиад сурвалжид 忽必撒刺 (hou-pi sa-la) хэмээн тэмдэглэсэн байх бөгөөд ер монголчуудын сарын уламжлалт нэрийн талаар судлаач Г.Мэнэсийн сонирхолтой судалгаа байдаг<sup>7</sup>.

Ордост 10 дугаар сарыг мөн хуви сар хэмээн нэрлэдэг нь эртний улбаатай бөгөөд цагаан сартай холбоотой байх гэж үзэж буй билээ.

**Abstract:** The article introduces the Runic inscription found at Del Uul, and deciphers this inscription.

---

<sup>7</sup> Bügünd Gochoo Menes, Discovering the Secret History of the Mongols (A Contemporary Approach to A Veiled Secret), хэвлэлд бэлтгэсэн эх.